

Сургуулийн өмнөх боловсрол ба хүүхдийн бүтээлч үйл

Deng Xiu Zhen,

ӨМӨЗО-ны Шилийн голын ажил мэргэжлийн дээд сургууль

Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэн бодох чадвар / бүтээлчээр сэтгэх/-ийг үнэлэх асуудал болно. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн гүйцэтгэлийн дүнгээс харахад тэдний сэтгэн бодох чадвар дундаж түвшинд байна. Хүүхдийн хөгжлийг зөв удирдах, амжилттай суралцах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тэдний оюун ухааны хөгжлийг судлан, сургалтад хамгийн чухал үүрэг гүйцэтгэх бүтээлч сэтгэлгээний хөгжлийг судалж, хөгжүүлэх шаардлагатай байгаа асуудлыг судлан санал, дүгнэлт дэвшүүлсэн болно. Таван настай хүүхдийн бүтээлч сэтгэлгээний чадвар ($x=1.76$ буюу 40,5) хангалтгүй дундаж хэмжээнд хөгжсөн байна. Хангалтгүй үнэлгээн дээр үндэслэн тэд даалгаварыг яагаад буруу хийж хангалтгүй үнэлгээ авав, ямар хүчин зүйл нөлөөлсөн тухай асуудалд үндэслэн судалгааны ажлын дүгнэлтийг хийсэн бөгөөд цаашид сэтгэхүйн бүтээлч сэтгэлгээний чадваруудыг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөртэй байх, сургуулийн өмнөх наснаас нь эхлэн тэдний сэтгэхүйг хөгжүүлэх, сургуульд орох бэлтгэлийг хангах асуудлыг онцгой анхаарах шаардлагатай байгааг судалгааны дүн харуулж байна.

Түлхүүр үг

Бага насны хөгжил, сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн өмнөх боловсролын чанар, багшийн хөгжил, тогтвортой хөгжил

Удиртгал

Хүүхэд бага наснаасаа сониуч, бүхнийг өөрөө хийх сонирхолтой байдаг. Хүүхдийг багаас нь ямар нэгэн үүрэг хүлээдэг, хүлээсэн үүргээ биелүүлэхийн төлөө чармайдаг, аливаад хариуцлагатай хандах сэтгэлгээтэй болгон төлөвшүүлж, бүтээлч хандлагатай хүн болгож хүмүүжүүлэх нь эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгчийн үүрэг билээ.

Сүүлийн жилүүдэд боловсролын шинэчлэлийн хүрээнд хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхийн тулд нас бүрийн онцлогийг тооцох хэрэгтэй гэдгийг эцэг эхчүүд илүү сайн мэдэх болоод байна. Хүүхдээ зургаан сар хүрснээс хойш өглөө бүр түүнтэй нэгэн хэвийн маягаар мэндэлж байгаарай хэмээн сэтгэл зүйчид зөвлөдөг. Сэтгэл зүйчдийн зөвлөснөөр энэ насанд хүүхэд “богино ой тогтоолттой” байдаг гэнэ. Иймээс хүүхэд өдрөөс өдөрт байнга давтагддаг юмыг амархан тогтоодог. Эцэг, эх бүр ийм байдлаар хүүхдийнхээ ой тогтоолыг хөгжүүлснээр хөгжлийг зохих түвшинд хүргэж чаддаг байна. Хүүхэд бүрийн ой тогтоолт, анхаарал төвлөрөлт өөр өөр байдаг тул багаас нь ой тогтоолтыг нь хөгжүүлэх дасгал хийлгэж байх хэрэгтэй. Хүүхдийн тархинд маш нарийн сэтгэх ажиллагаа явагдаж байдаг. Тиймээс зөвхөн цэцэрлэгийн орчин бус хүүхдийн оюун ухааны хөгжилд эцэг, эхчүүдийн оролцоо үүрэг

ихээхэн нөлөөлдөг гэдгийн нотолгоо эндээс харагдаж байна.

Хүүхдийн бүтээлч үйл ба эцэг, эхийн үүрэг

Хүүхдийг цэцэрлэгийн насанд нь тоглоомоор дамжуулж ертөнцийг таниулж ирсэн байна. Жишээлбэл, Эхлээд хүүхдэдээ үлгэрийн номыг дахин дахин уншиж өгөөрэй. Түүнээс гадна сэтгэл судлаачид хүүхэд өнгөрсөн үйл явдал ба түүнтэй холбоотой мэдээллийг сайн тогтоодог хэмээн үздэг. Цэцэрлэгийн насны хүүхэд урьдчилан ярьж өгсний дараа болсон үйл явдлыг илүү тогтоодог. Жишээлбэл, жүжиг үзэхийн өмнө ямар үйл явдал тухайн жүжигт гарах тухай ярьж өгвөл тухайн жүжгийн үйл явдлыг хэзээ ч мартдаггүй байна.

Хүүхдийн сэтгэхүй бодит үйлдлээс бодит дүрслэлд, үүнээсээ хийсвэр сэтгэхүй рүү шилжин хөгжиж байдаг зүй тогтолтой гэж үздэг. Тэд бодит дүрс загваруудад тулгуурлан сэтгэнэ. Ингэхдээ энгийн ухагдахуун, бодит юмсыг жиших, харьцуулах, төрөлжүүлэх, бүлэглэх, задлан шинжлэх зэрэг сэтгэхүйн энгийн арга барицыг эзэмшиж байдаг. Энэ үед хүүхэд юмс үзэгдлийн гадаад төрх байдлаас дотоод мөн чанар руу шилжиж, улмаар түүний сэтгэхүйн хөгжил д

✉ 55696190@qq.com

чанарын өөрчлөлт гарч эхэлнэ. (Санжжав, 2013, х-10)

Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн 80-90 хувь нь эцэг эх, гэр бүлийн нөлөөнөөс бий болдог гэж судлаачид үзсэн байдаг. Вайл Коулмэн ба Черчилль /1997/ нар илүү нарийвчилсан гэр бүлийн оролцоо нь сэтгэл хөдлөлийн болон бүтээлч сэтгэлгээний хөгжлийг дэмжсэн хөтөлбөрөөр /орчин нөхцөл, харилцаагаар/ хангах, эцэг, эхчүүдийг чадавхижуулах, багш нарыг хүүхэдтэй ажиллах, харилцах аргаар хангах гэх мэт олон төрлийн бүртгэлтэй байна хэмээн үзсэн байдаг. (Сарантуяа, Г, Болдсүрэн, Б нар, 2016, х-322) Хүүхэд хүмүүжүүлэх уламжлалт монгол арга нь аав, ээж нар өөрийнхөө биеэр үлгэрлэн дуурайлж, бага наснаас нь ажил амьдралд сургаж байсан бол өнөөгийн аав, ээжүүд бараг өглөөнөөс орой хүртэл хүүхдийнхээ барааг хардаггүй. Бид өнөөг хүртэл хүүхдийг яаж бүтээлч сэтгэхүйтэй иргэн болгож хүмүүжүүлэх вэ? гэдэг арга зүйг олж чадаагүй л явна. Гадаад улс орны сурган хүмүүжүүлэгчид сургуулийн өмнөх насны хүүхдийг төлөвшүүлэх асуудлыг хэрхэн шийдэж байна вэ?. Бага насны хүүхдийн хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт бол 6 хүртэлх насны хүүхэд бүрийг чанартай боловсролын үйлчилгээнд хамруулснаар улс орны ирээдүй хөгжлийн нэг чухал баганыг бэхэлж буй ач тустай үйл хэрэг болох юм хэмээн үзэж байгаа ч хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, хөгжил, төлөвшилд гэр бүлийн орчны нөлөө голлох үүрэгтэй байгааг мартаж болохгүй.

Хүүхдийн бүтээлч үйл ба цэцэрлэгийн үүрэг:

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдүүд хамрагдаагүй хүүхдүүдтэй харьцуулбал, ерөнхий боловсролын сургуулиа дүүргэх магадлал 25 хувиар илүү; тасралтгүй, амжилттай ажил эрхлэх магадлал нь 19 хувиар илүү; цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүд оюун ухааны чадвар нь 17 хүртэлх оноогоор илүү байдаг байна (Цэвээнлхазал.Я. 2011,х-108).

Дээрх тоон үзүүлэлтүүд нь бага насны хүүхдийн хөгжлийг боловсролын хүрээнд дэмжих нь чадварлаг ирээдүйн иргэнийг бий болгох гол хөшүүрэг гэдгийн нотолгоо болж байна. Х.Гарднерийн /1986/ оюун ухааны хөгжлийн цогцолбор онол ёсоор, оюун ухааны чадамжийн багц нь өөртөө хэл ярианы, хөгжмийн математик логикийн, орон зайн, биеийн хөдөлгөөн тэнцвэрийн, хүмүүс хоорондын харилцааны, өөртөө тунгаан бодох буюу бясалгах чиглэл давамгайлсан зэрэг 7 чадамжийг агуулдаг хэмээн үздэг.

Түүнчлэн сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжилтний чанарыг сайжруулах нь дэлхий нийтийн анхаарал хандуулж буй гол асуудал болж байна. Өдгөө сургуулийн өмнөх боловсролын багшийг бэлтгэж байгаа сургалтын хөтөлбөрийг нийгмийн болон бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, бага насны монгол хүүхдийн хөгжлийн суурь судалгаа хангалтгүй байгаа бөгөөд хүүхдээ судалж байж хүүхдийг хөгжүүлнэ гэдгийг ухамсарлах нь боловсролын салбарын амжилтын гол зүйл болно.

Судалгааны хэсэг

Энэ удаагийн илтгэлд 5 настай хүүхдийн бүтээлч үйлийг шинжлэн судалсан зарим үр дүнг танилцуулах болно. Бид 5 настай хүүхдийн сэтгэх чадвар бүтээлч, сэтгэлгээний онцлогийг судлахдаа сэтгэлзүйч Л.А.Ясюковагийн (Тунгалаг.О. 2016, х-84) боловсруулсан арга зүйгээр судалсан болно. Даалгаврын үр дүнг боловсруулахдаа зөв хариулт бүрд 1 оноо өгнө. Нийт 4 оноо авах ёстой. Харин хариулт буруу бол 0 оноо буюу ойлгож, сэтгэхийн өмнөх үе шатанд байна гэж үзнэ. Бидний судалгаанд Хөххотын 2 цэцэрлэгийн 50 хүүхэд хамрагдсан болно.

Бид БНХАУ, ӨМӨЗО-ны таван настай хүүхдийн бүтээлч сэтгэлгээний чадварыг үнэлэх нийтлэг аргачлалаар 5 настай 50 (28 эмэгтэй, 22 эрэгтэй) хүүхдийн бүтээлч сэтгэлгээний хөгжил, шинж байдлыг судалсан. Хүүхэд бүрийн “цэг холбон хялбар аргаар зурлага бичиж, зурлагаа ашиглан хүүхэд бүр хүссэн дүрсээ үүсгэн зурж будах, тоо бодох, өгүүлбэр зохиох зэргээр хүүхдийн бүтээлч сэтгэхүй, баруун тархины хөгжлийг дэмжиж, хэл яриаг хөгжүүлж, цэцэрлэгийн багш нарын сайн туршлагыг түгээх ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн болно.

1. Судалгааны арга зүй

Бэлтгэл үе шат – Онол аргазүйн судалгаа, хэрэглэгдэхүүн бэлтгэх

Судалгаа хийх үе шат – Тургигдагч эрэгтэй 22, эмэгтэй – 28 хүүхэд

Үр дүн – Судалгааны дүгнэлт, сургалтад хэрэглэх

Судалгааны зорилго

5 настай хүүхдийн бүтээлч сэтгэлгээний чадварыг судалсанаар 5 насны хүүхдийн оюун ухааны онцлогийг илрүүлэх

Судалгааны зорилт

Бага насны хүүхдийн бүтээлч сэтгэлгээний талаарх онол, арга зүйн материал уншиж судлан дүн шинжилгээ хийх

Судалгааны шалгуур үзүүлэлт боловсруулах

Судалгааны явц, үр дүнг тооцох

Шалгуур-1

1. Дүрсүүд ашиглан эвлүүлэх

Үзүүлэлт

1. Дүрсийг ашиглан бүтээл хийж чадаж байвал-4 оноо
2. Дүрсийг ашиглан бүтээл хийхийг оролдож байвал-3 оноо
3. Дүрсээ муруй хайчилж байвал-2 оноо
4. Бусдын тусламжтай хайчилж байвал 1 оноо
5. Огт чадахгүй бол-0

Шалгуур-2

1. Эвлүүлсэн дүрсээ тайлбарлан ярих

Үзүүлэлт

1. Дүрсээ зөв тайлбарлан ярьж байвал-5 оноо
2. Дүрсээ зөв тайлбарлах гэж оролдож байвал-4 оноо
3. Дүрсээ тайлбарлаж байвал-3 оноо
4. Дүрсээ дутуу тайлбарлан ярьж байвал -2 оноо
5. Дүрсээ бусдын тусламжтайгаар тайлбарлан ярьж байвал-1 оноо
6. Огт чадахгүй бол-0

5 насны хүүхдийн дүрс сэтгэн бодох чадварт хийсэн судалгааны явц, үр дүн

Судалгаа 1. Байдлыг тогтоох

Хүснэгт 1. Дүрс ашиглан бүтээл хийх үйлд хийсэн судалгаа (Зүрх цэцэрлэг)

№	Үзүүлэлт Туршигдагч	Нас	Хүйс	Дүрс эвлүүлэх		Дүрсийг тайлбарлан ярих		Бүгд оноо
				2018он 03.10-11	2018он 03.12-13	2018он 03.15-16	2018он 03.18-20	
1	Х	5	Эр	3	3	2	3	12
2	Ц	4,7	Эр	3	4	3	4	14
3	Б	4,9	Эр	2	3	1	3	10
4	О	4,2	Эр	3	2	2	2	9
5	Ч	4,9	Эр	1	4	1	3	8
6	Ө	5	Эм	2	4	3	3	11
7	Х	5	Эм	1	3	3	4	8
8	А	4,8	Эм	5	2	3	4	16
9	Г	4,10	Эм	3	4	4	3	14
10	Э	4,11	Эм	4	4	2	3	15
Нийт оноо				26	36	20	35	121
Хувь				52%	72%	40%	70%	

Хүснэгт 2. Эвлүүлсэн дүрсийг тайлбарлан ярих чадварт хийсэн судалгаа (Багачууд цэцэрлэг)

№	Үзүүлэлт Туршигдагч	Нас	Хүйс	Дугуй дүрсээр бүтээл хийх		Гурвалжин дүрсээр бүтээл хийх		Бүгд оноо
				2018он 03.22-23	2018он 03.26-27	2018он 03.28-29	2018он 03.29-30	
1	Г	4,11	Эр	1	3	1	3	9
2	Б	4,11	Эр	3	2	2	2	13
3	Б	5,0	Эр	1	4	1	3	10
4	Б	4,8	Эр	1	3	2	3	11
5	А	4,6	Эр	1	4	1	4	10
6	С	4,11	Эм	2	3	1	4	8

7	М	4,7	Эм	3	4	2	4	11
8	Ц	4,2	Эм	4	3	0	3	9
9	А	5	Эм	2	4	1	4	8
10	Э	4,11	Эм	1	4	2	3	10
Нийт оноо				18	39	13	33	100
Хувь				36%	78%	25%	66%	

Таван настай хүүхдийн бүтээлч сэтгэлгээний чадварын үйлийг судлахад: Зүрх цэцэрлэгийн хүүхдүүд 3 сард 52%, 5 сард 72%-тай буюу 20%-иар ахисан. Багачууд дугаар цэцэрлэгийн хүүхдүүд 3 сард 36%, 5 сард 60%

ба 24%-иар өссөн үзүүлэлттэй байна. Бидний судалгаагаар, үндсэн үзүүлэлт тус бүрээр 5 настай хүүхдийн үзүүлэлтүүд харилцан адилгүй байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Таван настай хүүхдүүдийн сэтгэн болох чадварын түвшин

Үзүүлэлт	Min	x		m	σ	Vc
	Max	оноо	%			
Даалгавар						
Сэтгэн бодох чадвар	,02-6,00	1.760	52.4	0.07	,9978	,1001

Бидний судалгаагаар 5 настай хүүхдийн сэтгэн бодох чадварын түвшин дунджаар ($x=1.76$ буюу нийт даалгаварынхаа 40,5%-ийн гүйцэтгэх чадвартай нь тогтоогдлоо. Эндээс харвал 5 настай хүүхдийн бүтээлч сэтгэн бодох чадвар тийм ч сайн биш дундаж хэмжээнд байгаа нь харагдаж байна. Хүүхдийн сэтгэн бодох, бүтээлч сэтгэлгээний чадварыг хөгжүүлэхийн тулд бие даан бүтээлчээр зурах, бүтээлийн сан хийх сургалтыг зохион байгуулж, үнэлэв.

Хүүхдэд гарсан өөрчлөлт:

1. Гарын жижиг булчинг хөгжүүлж, зурж бичих дадалд суралцсан
2. Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, бүтээлийн сантай болсон
3. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжихэд хамтран оролцдог болсон
4. Хүүхдэд, өөртөө итгэлтэй зан чанар төлөвшиж, бие даах чадвар нэмэгдсэн

Багшид гарсан өөрчлөлт:

1. Хүүхдийн хөгжлийн түвшинг тогтоох судалгааны баримттай болсон
2. СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрийн агуулгын хүрээнд хүүхдийн оюун ухаан сэтгэлгээг нэгдмэл байдлаар хөгжүүлэх аргад суралцсан
3. Хүүхдийн ахисан түвшинг үнэлэхэд ашигласан

Дүгнэлт

Судалгааны эхэнд хүүхдүүдэд бүтээлчээр сэтгүүлэх эвлүүлдэг даалгавар өгч ямар ч тайлбаргүй ажиглан хэрхэн эвлүүлж байгааг баримтжуулан судалгаа хийсэн болно. Энэ үед хүүхдүүд дүрсээ удаан ажиглаж, эсвэл хаа хамаагүй энд тэнд тавьж эвлүүлэх гэж оролдох эвлүүлж чадахгүй байх зэрэг алдаанууд гарч байсан. Хэд хэдэн удаагийн дүрс эвлүүлэх хичээлээр хүүхдийн аргагүй сайжирч дараа дараагийн дүрсүүдийг хурдан хугацаанд эвлүүлэх аргазүйг эзэмшив.

Судалгаанд хамрагдсан 5 настай хүүхдүүдийн сэтгэн бодох чадварын үзүүлэлтүүд нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанартай холбоотой байна. Өөрөөр хэлбэл бага насны хүүхэд чанартай сургуулийн өмнөх боловсролд хамрагдснаар сэтгэн бодох чадвар, бүтээлч сэтгэлгээний чадварыг илүү олж авч байна.

Судалгаагаар манай СӨБ-ын стандартын агуулгад бүрэлдэхүүн хэсэг, шалгуур үзүүлэлт, насанд хүрэгчдэд зориулсан үйл ажиллагааны чиглэл огт тусгагдаагүй бөгөөд бага насны хүүхдийн эзэмшсэн байх чадваруудын зарим нь стандарт боловсруулах, зарим нь шалгуур үзүүлэлт байхад тохиромжтой, хоорондоо давхцсан болох нь тодорхой харагдаж байлаа. Иймээс дээрх агуулгын хүрээ чиглэл, тодорхойлолтыг нэмж засварлах, стандартын шалгуур үзүүлэлтын хоорондын ялгааг арилгах, үгүйлэгдэж байгаа насанд хүрэгчдэд чиглэсэн үйл ажиллагааг БННХС-ын агуулгад багтааж өгсөн нь хүүхдийг цогц байдлаар хөгжүүлэх зорилгод нийсэн стандарт боллоо гэж үзэж байна.

Ном зүй

Тунгалаг, О. (2016). Зургаан настай хүүхдийн сэтгэхүйг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх үйлдлийг судалсан үр дүн. Лавай, Эрдэм шинжилгээний бичиг. Edu press хэвлэх үйлдвэр

Санжжав, Д. (2013). Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх судлал. Улаанбаатар

Цэвээнлэхал, Я. (2011). 6-8 насны сурагчдын сэтгэхүйн үйлдлийн хөгжлийг судлах

асуудалд. Лавай, Эрдэм шинжилгээний бичиг. Edu press хэвлэх үйлдвэр

Сарантуяа, Г, Болдсүрэн, Б нар, (2016) Сургуулийн өмнөх насны хүүхдийн нийгэмшгийн хөгжил, насанд хүрэгчдийн дэмжлэгийн судалгаа, Сургуулийн өмнөх болон бага боловсролын асуудал, шийдэл хурлын эмхэтгэл. Edu press хэвлэх үйлдвэр

PRESCHOOL EDUCATION AND CREATIVITY OF CHILDREN

Deng Xiu Zhen,

Xilingol Vocational College, Inner Mongolia Autonomous Region

Abstract

The purpose of this survey is to evaluate creative thinking skills /creative mentality/ of preschool children. Based on the assignment grades of the children participated in the survey, their level of creative thinking is at average. In order to have a right leadership in children's development and create the environment to learn successfully, it is necessary to propose ideas and summary on studying their intellectual development, creative thinking development which has the most important role in learning, and challenges that need to be developed. The creative thinking ability of a five-year-old child ($x=1.76$ or 40.5) was developed at an unsatisfactory average level. The survey conclusion was derived from the basis of unsatisfactory evaluation including why they completed the assignments wrong and received average evaluation, what factors affected this outcome, and that the survey result shows the necessity to give special attention to further developing creative thinking skills, setting curriculum, developing children's creativity from preschool education, and preparing them for school.

Key words

Early childhood development, preschool education, preschool quality, teacher development and sustainable development